АЖЛЫН БАЙРНЫ ЗАР · 2026 оны 2-р сарын 9

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР



Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн жинхэнэ албан хаагчдыг Улсын ерөнхий прокурорын газрын "Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн"-ий албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал

1. Хүсэлт
2. Төрийн албан хаагчийн анкет;
3. Гурван үеийн намтар;
4. Иргэний үнэмлэхийн хуулбар;
5. Боловсролын түвшин тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
6. Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
7. Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа /e-mongolia–аас татан авах/;
8. Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
9. Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
10. Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
11. Цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэний хувьд цэргийн үүрэгтний үнэмлэх;
12. Сахилгын шийтгэлтэй эсэх тодорхойлолт
13. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/.

Материал хүлээнг авах:

- Хугацаа: 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 17:00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: s.siilegmaa@prosecutor.mn цахим шуудангаар
- Холбоо барих утас: 51-260855, 88019466 /ажлын цагаар/

АЛБАН ТУШААЛЫН ТУСГАЙ ШААРДЛАГА

Улсын ерөнхий прокурорын газар	Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтсийн Олон нийттэй харилцах алба	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, АА-10	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	-Дуу дүрсийн техник болон медиа үйлдвэрлэл (0211), -мэдээлэл харилцаа холбооны технологиуд (061)	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/289